



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар A/115

Улаанбаатар хот

“Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах заавар” шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.7, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.9, 8.10.11 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компаниар дамжуулан “Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах заавар”-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг 2017 оны 07 дугаар сарын 05–ны өдрөөс эхлэн мөрдөж, гишүүн үнэт цаасны компанид болон нийтэд мэдээлэхийг Арилжаа, бүртгэлийн алба /Д.Тогтохбаяр/-нд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /В.Буянмөнх/-т даалгасугай.
4. Энэхүү зааврыг шинэчлэн баталсантай холбогдуулан МХБ-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-66 тоот тушаалаар баталсан “Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах заавар”-ыг хүчингүйд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын
2017 оны 07 дугаар сарын 04 өдрийн
А/1.1.5 дугаар тушаалын хавсралт



**ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН
АРИЛЖААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**
/Шинэчилсэн найруулга/

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Энэхүү зааврын зорилго нь Засгийн газрын үнэт цаасыг /цаашид “ЗГҮЦ” гэх/ “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид МХБ гэх/-иар дамжуулан нийтэд санал болгон арилжаалах анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
2. Энэхүү харилцаанд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын “Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжих журам”-ыг удирдлага болгоно.
3. ЗГҮЦ-ны арилжааг дараах хэлбэрээр явуулна. Үүнд:
 - 3.1 Арилжаалах ЗГҮЦ-ны хүүгийн хувь хэмжээг зах зээлийн жишиг хүүд үндэслэн тогтоох буюу өрсөлдөөнт бус арилжаа;
 - 3.2 Арилжаалах ЗГҮЦ-ны хүүгийн хувь хэмжээг /цаашид өгөөж гэх/ дуудлага худалдаанд үндэслэн тогтоох буюу өрсөлдөөнт арилжаа;
4. Энэхүү зааварт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 4.1. “Хүү хуримтлуулж эхлэх өдөр” гэж ЗГҮЦ-нд хүү тооцож эхлэх өдрийг эсхүл төлбөр тооцоо хийх өдөр нь арилжаа явагдсан өдрөөс хойш бол үнэт цаасны төлбөр тооцоо хийх өдрийг;
 - 4.2. “Төлбөр тооцооны өдөр” гэж ЗГҮЦ-ны арилжаагаар худалдан авсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх өдрийг;
5. Арилжаанд зөвхөн Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/-ноос үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл авсан, МХБ-ийн гишүүн ҮЦК-ийн төлөөлөгч /цаашид арилжаанд оролцогч гэх/ оролцоно.

Хоёр. ЗГҮЦ-НЫ ӨРСӨЛДӨӨНТ БУС АРИЛЖАА

1. Үнэт цаас гаргагч Монгол Улсын Сангийн яамны үнэт цаас бүртгүүлэх өргөдлийг үндэслэн Засгийн газрын үнэт цаасыг бүртгэх, нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжих тухай МХБ-ийн Гүйцэтгэх захирлын шийдвэр гарна. Уг шийдвэрийг үндэслэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д үнэт цаас хадгалуулах мэдэгдэл хүргүүлнэ.

2. Арилжаанд оролцогч нь тогтоосон үнээс өндөр эсвэл доогуур үнээр ЗГҮЦ худалдан авах захиалга өгч болохгүй.
3. Арилжаанд оролцогч нь өөрийн болон харилцагчийн захиалгыг анхдагч зах зээлийн арилжааны програмд долоо хоног бүрийн Мягмар гарагт 10.00-11.30 цагийн хооронд оруулна.
4. ЗГҮЦ-ны худалдан авах захиалгын арилжааны программд оруулах хугацаа дууссаны дараа МХБ нийт захиалгын жагсаалтыг үнэт цаас гаргагч Сангийн яаманд хүргүүлэх ба хувиарлалтыг Сангийн яам хийнэ.

Гурав. ЗГҮЦ-НЫ ДУУДЛАГА АРИЛЖАА БУЮУ ӨРСӨЛДӨӨНТ АРИЛЖАА

1. Дуудлага арилжаа дараах 3 үе шаттайгаар явагдана. Үүнд:
 - 1.1. Худалдан авах захиалга бүртгэх үе
 - 1.2. Дуудах үе
 - 1.3. Хэлцэл хийгдэх үе
2. Арилжаанд оролцогч нь өөрийн болон харилцагчийн захиалгын өгөөжийн хувь хэмжээ болон тоо ширхэгийг анхдагч зах зээлийн арилжааны программд долоо хоног бүрийн Лхагва гарагт дуудлага арилжааны захиалга бүртгэх үе буюу 10.00-11.00 цагийн хооронд оруулна.
3. Арилжаанд оролцогчдод нэгж үнэт цаасны худалдах өгөөжийг зарласнаар худалдан авах захиалга бүртгэх үе эхэлнэ. Худалдан авах захиалга бүртгэх үе 60 минут үргэлжилнэ.
4. Зөвхөн захиалга бүртгэх үед арилжааны программд бүртгэгдсэн захиалга нь дуудах үед оролцон үнэ хаялцах эрхтэй бөгөөд дуудах хугацаа 40 секунд байна.
5. Дуудах үед арилжааны программд бүртгэгдсэн захиалгын өгөөжид өөрчлөлт орсоноос хойш дараагийн өгөөжийг оруулах боломжит хугацаа 40 секундээр сунгагдана.
6. Дуудах үе эхэлснээс хойш 40 секундийн хугацаанд худалдан авах захиалгын өгөөжид өөрчлөлт ороогүй эсвэл программд бүртгэгдсэн худалдан авах захиалгын өгөөж хамгийн сүүлд өөрчлөлт орсноос хойш 40 секундын хугацаанд дахин өөрчлөлт ороогүй тохиолдолд хэлцэл хийгдэнэ.
7. Дуудлага арилжааны явцад дуудах хугацаа дуусахад худалдан авах хамгийн бага өгөөжийн сонголтод хамрагдсан өгөөжүүдийн түвшинд хэлцэл биелэгдэх ба өгөөжийн түвшин тэнцсэн тохиолдолд цаг хугацааны дарааллаар хэлцэл биелэгдэнэ.
8. Дуудлага арилжааны дуудах үед арилжаанд оролцогчид өөрийн болон харилцагчийн захиалгын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж, цуцалж болохгүй.

9. Дуудлага арилжааны дуудах үед анхны өгөөжөөс бууруулан дуудах хамгийн бага нэгж нь зууны нэг хүртэл нарийвчлалтай буюу 0.01 нэгж байна.
10. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн нөхцлийн дагуу нэг харилцагчийн ЗГҮЦ худалдан авах захиалгын дээд хэмжээг заасан хязгаарлалтыг хийж болно.
11. МХБ нь дараа долоо хоногт арилжаалах ЗГҮЦ-ны өгөөжийн хэмжээг долоо хоног бүрийн Лхагва гарагт www.mse.mn цахим хуудсанд мэдээлнэ.
12. Арилжааг эрчим хүчний түр саатал, техник програм хангамжийн гэмтэл болон бусад давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан цуцалж болно.
13. Үнэт цаас гаргагч Сангийн яам арилжааг цуцалсан тохиолдолд арилжаа зохион байгуулагчаар дамжуулан дараагийн арилжаа явагдах огноо, цагийг мэдэгдэнэ.

Дөрөв. ТӨЛБӨР ТООЦОО

1. Хөрөнгө оруулагч ЗГҮЦ-ны төлбөрийг арилжааны шимтгэлийн хамт Арилжааны төлбөр тооцоо /цаашид АТТ гэх/ дахь өөрийн нэрийн 12 оронтой дансыг зааж арилжааны банкаар дамжуулан АТТ-ны дансанд урьдчилан байршуулна.

Тав. БУСАД

1. Арилжаа явагдсан өдөр бүр ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны мэдээг олон нийтэд МХБ-ийн www.mse.mn вэб сайтаар дамжуулан тогтмол хүргэнэ.
2. ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаатай холбогдон гарсан аливаа санал гомдлыг энэхүү заавар болон МХБ-ийн хяналтын журмын дагуу шийдвэрлэнэ.